



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/20/СТА-ТТЗ

---

Баянхонгор хот. 2019 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 7044-2584      Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: Д.Цэцэгмаа Утас: 7044-2424      Цахим хаяг: tsetsegmaad@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Должмаа Утас: 88119345      Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
-------------------------	--

---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1	Аудитын гэрчилгээ.....	3
2	Аудитын тайлан .....	5
	2.1. Оршил.....	5
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	6
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	8
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
	2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар .....	9
	2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар .....	10
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .	10
	2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	10
	2.11. Шилэн дансны мэдээлэл .....	11
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
	2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:.....	11
	2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	13
3	Менежментийн захидал .....	14
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	15
	4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15

---

## 1 Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум  
Утас, факс 70-44-25-84  
E-mail; bayankhongor@audit.gov.mn

2019.03.25 № 2/151

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 8.9.3-д заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

#### **Зөрчилгүй санал дүгнэлт**

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

#### **Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2515286


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Баян-Өндөр сумын Засаг дарга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Сумын Засаг дарга У.Балжиннямд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2,8.9.3-д заасны дагуу Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.03.19-нөөс 2019.03.21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.03.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б. Должмаа хариуцаж хэрэгжүүлэв.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баян-Өндөр сумын Засаг даргын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баян-Өндөр сумын Засаг дарга нь “Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баян-Өндөр сумын Засаг дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Байхгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 8 байгууллага, нэгж 2018 оны санхүүгийн тайландаа аудит хийж баталгаажуулахаас 8 байгууллага аудитад хамрагдсан байна.

Төрийн аудитын байгууллагаас Баян-Өндөр сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр						
№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	3	3	-	2	-
2	ТБӨӨААН	-	-	-	-	-
	Дүн	3	3	-	2	-

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Баян-Өндөр сумын Засаг даргын харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баян-Өндөр сумын төсөвт байгууллагууд санхүүгийн тайланг бэлтгэхдээ "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн Acolous 4.01, цалингийн Payroll программаар, харин санхүүгийн нэгтгэсэн тайланг Э-тайлан" програм хангамж ашиглаж бэлтгэсэн байна.

Баян-Өндөр сумын Засаг даргын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөгүй гэж үзлээ.

Баян-Өндөр сумын Засаг даргын дэргэд дотоод аудитын алба байхгүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд төрийн аудитын байгууллагаас хяналт шалгалт хийж, зөрчил илрээгүй байна.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баян-Өндөр сумын Засаг даргын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 4 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, мөнгөн дүн 1 тэрбум төгрөгөөс дээш дүнтэй тул зардлын дүнгийн 1 хувиар сонгов.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 2220109,4 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 22201,1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд шинж чанарын болон орчин нөхцлийн хувьд материаллаг байдал илрээгүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн материаллаг биш боловч цаашид санхүүгийн тайлан, тодруулгад материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй зарим асуудлыг толилуулж байна.

Баян-Өндөр сумын Засаг дарга болон төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагчийн хэмжээнд 16994,2 мянган төгрөгийн алдаа илэрч, 5679,6 мянган төгрөгийн

алдааг аудитын явцад залруулав. Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд алдаа зөрчил илрээгүй.

Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлыг хэрхэн ангилж, шийдвэрлэсэн байдлыг энэ тайлангийн 2.13-т нэгтгэсэн байдлаар үзүүлэв.

Асуудлыг өмнөх түвшинд хийсэн аудитын явцад гарсан асуудал, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийх явцад түүвэрт хамрагдсан асуудлаас илэрсэн асуудал гэсэн ангилалаар үзүүлэв. Үүнд:

### **2.8.1 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад хийсэн аудитын дүнгийн талаар**

#### **Асуудал 1: (Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт)**

Сумын Сум хөгжүүлэх сангаас 2017.12.22-ны өдөр хөнгөлөлттэй зээл авсан Х.Баярмөнх 2018 онд төлөх 2,3 сая төгрөгийн зээлийг төлөөгүй, хугацаа хэтрүүлсэн байна.

**Шийдэл: Төлбөрийн акт тогтоосон.**

#### **Асуудал 2: (Зардлын данстай холбоотой асуудал)**

Сум хөгжүүлэх сангаас иргэдэд хөнгөлөлттэй зээл олгохдоо сумын Засаг дарга шийдвэр гаргаагүй байна.

**Шийдэл: Зээл олгохдоо холбогдох шийдвэрийг үндэслэн зээл олгох захирамжийг журмын дагуу гаргаж байх зөвлөмж өгсөн.**

#### **Асуудал 3: (Зардлын данстай холбоотой асуудал)**

Сумын ИТХ-ийн нягтлан бодогч жирэмсэн амарсан ажилтныг нийгмийн даатгалд мэдээлэхдээ 06 кодоор мэдээлэхийг 17 кодоор мэдээлсэн байна.

**Шийдэл: Жирэмсэн амаржсан хүний цалингийн кодыг зөв мэдээлж байх зөвлөмж өгсөн.**

#### **Асуудал 4: (Зардлын данстай холбоотой асуудал)**

Сумын ИТХ оны эцэст байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй 129990 төгрөгийн номыг тоолоогүй байна.

**Шийдэл: Эд хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэж, нярвын бэлтгэсэн тайланд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн.**

#### **Асуудал 5: (Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл)**

Тайлант хугацаанд цалингийн зардлаас бусад зардлын 145,0 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан. Үүнээс Нөөц хөрөнгийн зарцуулалтыг шалгахад сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,1 дэх заалтыг зөрчиж уралдаан тэмцээн зохион байгуулах, засвар үйлчилгээ хийх, нутгийн зөвлөлийн уулзалтын зардал, цэрэг татлагын хоолны зардал, лектор

урьж ажиллуулах зэрэг урсгал үйл ажиллагаанд 8,8 сая төгрөгийг зарцуулж, төсвийн үр ашиггүй зардал гаргасан байна.

**Шийдэл: Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,1 дэх заалтыг мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.**

#### **Асуудал 5: (Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл)**

Сумын ИТХ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулсан боловч төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан төсвийг 900,0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

**Шийдэл: Төсвийн гүйцэтгэлийн тайланд залруулга хийсэн.**

#### **Асуудал 6: (Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл)**

Сумын цэцэрлэгийн үндсэн хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой элэгдлийн бичилтийг тулган шалгахад 4779,6 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байна.

**Шийдэл: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.**

#### **2.8.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн шатанд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 0 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд санхүүгийн тайланд залруулга хийгээгүй болно.

#### **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Байхгүй.

#### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн төвлөрүүлэн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баян-Өндөр сумын Засаг даргын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 8 байгууллагын 9 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 1857620,3 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 1719304,3 мянган төгрөг буюу 92.5 хувь, зардлын нийт гүйцэтгэл 1685940,5 мянган төгрөг буюу 90.8 хувьтай байгаа нь дараахь шалтгаантай байна. Сумын ЭМТ-ийн эмчлэгч эмч мэргэжил дээшлүүлж эзгүй байгаа, сургуулийн менежерийн 1 орон тоо хасагдсан, эмч олдоогүйгээс орон тоо дутуу, Соёлын төвийн дуу хөгжмийн багш цэрэгт явсан зэргээс шалтгаалж, цалин, НДШ-ийн зардал 11,3 сая төгрөгөөр хэмнэгдсэн. Сургуулийн спорт заалны хана цуурснаас үйл ажиллагааг зогсоосноос халаалт салгаснаас халаалтын зардал 2,3 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-аас тоног төхөөрөмж нийлүүлэх болсон тул ИТХ-д тоног төхөөрөмж авахаар төлөвлөсөн 1,8 сая төгрөгийн эд хогшил худалдан авах зардал хэмнэгдсэн. Засгийн газрын дотоод шилжүүлэг буюу хөрөнгө бэлтгэх зардал 72,9 сая төгрөг батлагдсан боловч хүйтний улирал эхэлсэн тул ажил дутуу хийгдэж, 43,0 сая төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, зардлыг 29,9 сая төгрөгөөр хэмнэсэн. ОНХС 130,4 сая төгрөг батлагдсанаас 73,8 сая төгрөг зарцуулж, 57,4 сая төгрөг хэмнэгдсэн нь спорт заалны үлдэгдэл санхүүжилтийг улсын комисс хүлээн авсны дараа үлдэгдэл санхүүжилтийг олгох албан шаардлагыг СХАА-наас өгсөн зэрэгтэй холбоотой байна.

Сумын Соёлын төвд үндсэн үйл ажиллагааны орлогоор 2,0 сая төгрөг батлагдсаныг бүрэн оруулж төлөвлөгөөг биелүүлжээ. ЗДТГ өөрийн орлогоор 0,6 сая төгрөг оруулахаар батлагдаж, ноолуурын дуудлага худалдааны орлогоор төлөвлөгөөг 0,4 сая төгрөгөөр давуулж, 1,0 сая төгрөг оруулжээ. Сумын сургуульд заалны орлогоор 1,0 сая төгрөг оруулахаар батлагдсаныг бүрэн оруулжээ.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баян-Өндөр сумын Засаг дарга Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх онд итгэл үзүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт илэрсэн алдаа, зөрчлийн 33.0 хувь буюу 5679,6 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 14.0 хувь буюу 2300,0 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 53.0 хувь буюу 9014,6 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлжээ.

Төрийн аудитын байгууллагаас аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил түүний шийдвэрлэлийн байдлыг дор нэгтгэн үзүүлэв. Үүнд:

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

(Мянган төгрөг)

№	Байгууллагын ангилал	Илрүүлэлт						Залруулга	
		Зөрчил		Алдаа		Бүгд дүн		Тоо	Дүн
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-
2	ТШЗ	5	11314,6	2	5679,6	7	16994,2	2	5679,6
	Дүн	5	11314,6	2	5679,6	7	16994,2	2	5679,6

Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

(Мянган төгрөг)

Үүнээс: Залруулаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт

№	Байгууллагын ангилал	Залруулаагүй алдаа, зөрчил		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах санал			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	ТШЗ	5	11314,6	1	2300,0	-	-	4	9014,6	-	-	-	-
	Дүн	5	11314,6	1	2300,0	-	-	4	9014,6	-	-	-	-

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудын хүрээний байгууллагад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санал дүгнэлтийг нэгтгэн үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санал дүгнэлтийн хэлбэр (Тоогоор)				Дүн
		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан	
1	ТШЗ	5	-	-	-	5
2	ТБӨӨААН					
	Дүн	5	-	-	-	5

### **3 Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баян-Өндөр сумын Засаг даргын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Балансын данстай холбоотой асуудал**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд сумын төвлөрүүлэн захирагчийн батлагдсан төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг оруулаагүй байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Шилэн дансны тухай хуулийг холбогдох заалтыг зөрчсөн байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Хууль, тогтоомжийг хэрэгжүүлээгүй байх

##### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Төсвийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг тодорхой оруулж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 05 дугаар сарын 01-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>386,807,909.18</b>	<b>513,619,013.26</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	74,474,008.04	149,493,665.12
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	74,474,008.04	149,493,665.12
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	74,474,008.04	149,493,665.12
31211	Төрийн сангийн харилцах	74,474,008.04	149,493,665.12
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	151,647,000.00	177,036,900.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	2,646,900.00
3351	Байгууллагаас авах авлага	-	2,646,900.00
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	151,647,000.00	174,390,000.00
<b>3361</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	151,647,000.00	174,390,000.00
33612	Хувь хүмүүст олгосон зээл	151,647,000.00	174,390,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	160,686,901.14	187,088,448.14
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	2,614,492.00	3,899,810.00
35110	Тусгай зориулалттай материал	989,210.00	2,081,051.00
35130	Эм боох материал	1,625,282.00	1,818,759.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	149,814,009.14	180,435,838.14
35410	Бичиг хэргийн материал	2,919,500.00	4,080,580.00
35420	Аж ахуйн материал	2,141,150.00	2,440,000.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,598,000.00	638,600.00
35440	Түлш, шатах тослох материал	2,572,960.00	1,937,300.00
35450	Барилгын засварын материал	611,500.00	556,500.00
35460	Хүнсний материал	2,475,280.14	4,309,690.14
35470	Бусад хангамжийн материал	137,495,619.00	166,473,168.00
35600	Мал амьтад	8,258,400.00	2,752,800.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,066,195,256.33</b>	<b>3,424,198,787.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,066,195,256.33	3,424,198,787.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	3,065,894,214.56	3,351,298,245.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,323,610,400.00	4,358,953,622.29
39202	Хуримтлагдсан элэгдэл	(2,625,914,168.79)	(1,381,683,411.53)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	162,781,450.00	157,430,774.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(111,957,556.35)	(67,659,481.62)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	508,117,859.53	555,514,788.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	(369,226,771.54)	(411,813,636.17)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	197,825,278.30	195,443,976.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(122,158,939.85)	(132,909,500.37)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,072,478.00	1,072,478.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	127,340,397.00	49,954,371.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(80,003,621.74)	(28,352,362.64)
39217	Ном	54,407,410.00	55,346,628.00

**Баян-Өндөр сумын Засаг даргын 2018 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	301,041.77	72,900,541.81
39301	Програм хангамж	3,637,000.00	3,637,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,335,958.23)	(3,548,458.19)
39303	Бусад биет бус хөрөнгө		72,812,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,453,003,165.51</b>	<b>3,937,817,801.03</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,016,667.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	5,000,000.00	5,016,667.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	5,000,000.00	5,016,667.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	5,000,000.00	5,016,667.00
41361	Байгууллагад төлөх өглөг	5,000,000.00	5,000,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		16,667.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,448,003,165.51</b>	<b>3,932,801,134.03</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,448,003,165.51	3,932,801,134.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,974,093,094.00	2,046,905,094.00
51101	Өмч: - төрийн	1,974,093,094.00	2,046,905,094.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	313,400,630.41	45,173,188.49
51210	Өмнөх үеийн үр дүн	929,956,861.80	313,744,486.41
51220	Тайлант үеийн үр дүн	(616,556,231.39)	(268,571,297.92)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,160,509,441.10	1,840,722,851.54
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,453,003,165.51</b>	<b>3,937,817,801.03</b>

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

